


Улсын бүртгэлийн хэлтсийн 1 дэх 7 хоногт хийсэн ажил

2017.12.07

Энэ долоо хоногт хэлтсийн бүх тайланг гаргаж ОӨУБЕГ-т хүргүүлээ. Иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн тоон мэдээг дурьдвал:


1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд :

Төрсний бүртгэл 2635, хүүхэд үрчлүүлсний 102, овог, эцгийн нэр, нэр өөрчилсний 46, эцэг тогтоосны 37, гэрлэсний 800, гэрлэлт цуцалсны 19, гэрлэлт сэргээсний 0, нас барсны 377, засвар өөрчлөлтийн бүртгэлд 157 иргэн, нөхөн бүртгэлийн бүртгэлд 1315 иргэн тус тус бүртгэгдсэн байна.



Нөхөн бүртгэлийн журмаар бүртгэсэн 1315 бүртгэлийг задалж үзвэл: Үүнээс төрсний 154, үрчлэлтийн 11, гэрлэлтийн 717, нас баралтын 429 иргэн, гэрлэлт цуцлалтын бүртгэл 4 тус тус бүртгэгдсэн байна. Шүүхийн шийдвэр болон хяналтын байцаагчийн дүгнэлтээр 30 иргэнд регистрийн дугаар ХААТР-25 бичиж олгосон байна.


Тайлангийн хугацаанд холимог гэр бүлийн бүртгэлд нийт 57 иргэн хамрагдсанаас төрсний 28, гэрлэлт 5, гэрлэлт цуцлалтын 5, эцэг тогтоосны бүртгэл 14, нас баралт 5 иргэн тус тус бүртгэгдсэн байна. Төрсний гэрчилгээ дахин олголт 4, гэрлэсний гэрчилгээ дахин олголт 2, нас барсны гэрчилгээ дахин олголт 1 нийдтээ 6 гэрчилгээг дахин олгосон байна.



1.1. Цахим иргэний үнэмлэхийн бүртгэлийн чиглэлээр:

ОӨУБЕГ-аас хэвлэгдэж ирсэн 5095 иргэний цахим үнэмлэхийг хүлээн авч сумдаар нь ялгалт хийн, нэрсийн жагсаалтад авч нэгжийн бүртгэгчдэд хүлээлгэн өгсөн байна.

/хүснэгт 3/




25 насны 1533, 45 насны 1018 иргэн сунгалтанд хамрагдаж нийтдээ 2551 сунгалтын бүртгэлд баталгаажилт хийгдэж цахим үнэмлэх хэвлэгдсэн байна.

1.2. Үндэсний энгийн гадаад паспорт болон шилжин суурьших хөдөлгөөний бүртгэлээр

Тайлангийн хугацаанд шинээр үндэсний энгийн гадаад паспорт авахаар хүсэлт гаргасан 3688 иргэний материалыг шалган хүлээн авч үүнээс хэвлэгдэж ирсэн 3635 иргэний үндэсний энгийн гадаад паспортыг иргэнд олгосон байна. Гадаад паспортын тэмдэгтийн хураамжинд 18,175,000 /Арван найман сая нэг зуун далан таван мянга/ төгрөг төвлөрүүлсэн байна. Өмнө нь гадаад паспорт авсан боловч хүчинтэй хугацаа болон хуудас дууссан 927 иргэний паспортыг хүчингүй болгон дахин олгосон байна.

/хүснэгт 4/




Хүчинтэй хугацаа сунгалтын бүртгэлээр 2128 иргэний гадаад паспортын хугацааг сунган хурдан шуурхай үйлчилж тэмдэгтийн хураамжинд 5,320,000 /Таван сая гурван зуун хорин мянга / төгрөг төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны улсын Засгийн газар хоорондын 1994 оны хэлэлцээрээр Монгол-Оросын холбооны улсын хилийг хялбарчилсан журмаар тус аймгийн хил орчмын ОХУ-тай хил залгаа сумдын иргэдэд 1 ширхэг хил зорчих үнэмлэх олгосон байна.

Засгийн газрын 2002 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол улсын нутаг дэвсгэрт иргэдийн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх мэдээллэх журмыг мөрдлөг болгон ажилласан байна. Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн чиглэлээр нийтдээ 6257 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэлд хамрагдсанаас: аймаг хот руу бүрмөсөн шилжин явсан 294, аймаг хотоос бүрмөсөн шилжин ирсэн 258, хот доторхи шилжилт хөдөлгөөний бүртгэлд 5705 иргэн тус тус хамрагдсан байна.


/хүснэгт 5/



2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:


Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйл ажиллагааг хууль журмын дагуу явуулж 2017 онд үйлчилгээний хураамжаар 65.017.274 төгрөг, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхээ худалдан борлуулсаны 2%-ын татварын орлогоор 38.121.650 төгрөг, улсын тэмдэгтийн хураамжаар 1.663.746 төгрөг, нийт 104.802.670 төгрөгийн орлогыг орон нутгийн болон улсын төсөвт оруулсан байна.

Үйлчилгээний хураамж, Улсын тэмдэгтийн хураамж, 2%-ийн татвар.



Нийтдээ 8019 мэдүүлэ хүлээн авч хянан шийдвэрлэж үүнээс, газар өмчлөх эрхийн бүртгэл 380, газар эзэмших эрхийн бүртгэл 60, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл 460-г тус тус бүртгэж эрхийг нь баталгаажуулсан ба эрхийн улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлт, залруулга оруулах бүртгэл 394, өмчлөгчийн хүсэлтээр бүртгэлд өөрчлөлт оруулах эрхийн бүртгэл 33-г тус тус бүртгэж баталгаажуулсан болно.

Мэдүүлэг, анхны бүртгэл, гэрээ хэлцэл



Тайлангийн хугацаанд нийт 4935 гэрээ хэлцэл бүртгэж баталгаажуулсан бөгөөд худалдах худалдан авах гэрээ 245, бэлэглэх гэрээ 316, гэрээслэл болон өв залгамжлал 81, барьцааны гэрээ 1880, барьцаалбар 528, барьцааны гэрээ дуусгавар болгох 1762, хамтран өмчлөгч өөрчлөгдөх гэрээ 123-г тус тус бүртгэж баталгаажуулсан байна. 2017 оны байдлаар нийт 873 шинээр нээсэн хувийн хэргийг архивт хүлээж авсан бөгөөд үүний 466 нь газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, 407 нь газартай холбогдолтой хувийн хэрэг байна. Архиваас улсын бүртгэгчдэд 6397 хувийн хэргийг түр олгосон байна. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт бүгд 22834 хувийн хэрэг зохих журмын дагуу эмх цэгцтэй хадгалагдаж байна. Үүний 10697 нь газартай холбогдолтой хувийн хэрэг, үлдсэн 12137 нь газраас бусад үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдолтой хувийн хэргүүд байна.

2.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:

2017 оны 11 сарын 25-ны байдлаар нийтдээ 119 хуулийн этгээд шинээр, 32 хуулийн этгээд дахин гэрчилгээ авах, хэлбэр өөрчлөхөөр бичиг баримтаа журмын дагуу бүрдүүлэн гэрчилгээ авсан байна. Үүнд: ХХК-89, ТББ-18, сан-1, ҮЭБ-3, шашны байгууллага -3, хадгаламж зээлийн хоршоо-1, төсөвт байгууллага- 1, нөхөрлөл -2, хоршоо-1 тус тус нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд ХХК-ийн 2 хувийн хэрэг ХЭБГ-т шилжин явсан болно. Мөн ХЭБГ-аас 2 хувийн хэрэг шилжин ирж, 1 хувийн хэрэг Ховд аймагт тус тус шилжсэн байна.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС